



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 5/31

Модот

Д.Анхбаярыг ажилд томилох тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 145 дугаар зүйлийн 145.1, 145.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, Д.Анхбаярын бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дашзэвэгийн Анхбаярыг математик, физикийн багшийн албан тушаалд 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс томилон ажиллуулсугай.
2. Д.Анхбаярын үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар, хоолны нөхөн олговор, холбогдох бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Л.Ариунтунгалаг)-т зөвшөөрсүгэй.
3. Д.Анхбаярын мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг сургалтын менежер (Д.Ариунаа), эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Г.Золбоо) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Д.ОТГОНДУЛАМ

